



Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын
Элчин сайдын яам
Улаанбаатар

90 ХҮРТЭЛХ ХОНОГИЙН ШЕНГЕНИЙ ВИЗ (ЗОЧЛОХ, БИЗНЕС, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ)

ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

1. Дараах заавартай сайтар уншиж, танилцаад визийн мэдүүлэгт шаардлагатай бичиг баримтаа бүрдүүлнэ үү.
2. Таны **аяллын үндсэн зорилго** дараах орнуудын аль нэг байх тохиолдолд Улаанбаатар дахь Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Элчин сайдын яаманд Шенгений визийн мэдүүлгээ өгөх боломжтой: **Герман, Бельги, Люксембург, Словени, Латви, Дани, Испани, Португал, Грек, Исланд, Мальта, Финланд.**
3. Та **VFS GLOBAL** цахим хуудсанд бүртгэл үүсгээд хүссэн өдөртөө визийн мэдүүлгийн цагаа товлох боломжтой.
4. **Аялах өдрөөс ихдээ 6 сар, багадаа 4 долоо хоногийн өмнө** визийн мэдүүлгээ өгөх боломжтой. Богино хугацаанд шийдвэрлэх болсон визийн мэдүүлгийн хариуцлагыг Элчин сайдын яам хүлээхгүй.
5. **Визийн мэдүүлгийн хянан шийдвэрлэх хугацаа 10-14 хоног байна.** Зарим нэг тодорхой тохиолдолд үүнээс илүү хугацаа шаардагдаж болно. Элчин сайдын яам нь зарим тохиолдолд нэмэлт бичиг баримт шаардаж болно. Хуулиар зохицуулагдсан шийдвэрлэх хугацаа дуусаагүй байхад ямарваа нэгэн асуулт, тодруулгад хариу өгөх боломжгүй гэдгийг анхаарна уу. **Мөн мэдүүлгийг шийдвэрлэх хугацааг виз мэдүүлсэн хүний хүсэлтээр богиносгох боломжгүй.**
6. Та визийн мэдүүлэгт **VIDEX** цахим маягтыг бөглөнө.
7. Та VFS Global төвд тохирсон цагтаа биечлэн ирж бүрдүүлсэн бичиг баримтаа өгнө. Тус визийн мэдүүлгийн төв нь Таны хурууны хээг мөн авах болно. Хүүхдүүд 12 нас хүрсэн бол хурууны хээ өгнө.
8. **Визийн хураамж болон VFS GLOBAL үйлчилгээний хураамжийг хүн бүр төлнө.** Татгалзсан хариу авсан эсвэл визийн мэдүүлгээ эргүүлэн татсан тохиолдолд эдгээр хураамжийг буцаан олгохгүй. Мөн мэдүүлгээ ирүүлээгүй эсвэл дутуу мэдүүлсэн тохиолдолд VFS GLOBAL үйлчилгээний төлбөр хураамжийг буцаан олгохгүй болохыг анхаарна уу.
Хэрвээ Та товлосон цагтаа ирэх боломжгүй бол цагаа цуцална уу.
9. Монгол хэл дээрх баримт бичгийг заавал **герман эсвэл англи орчуулгын хамт өгнө.** Аливаа нэг албан бичиг, тодорхойлолт нь сүүлийн 2 долоо хоног дотор олгосон байх ёстойг анхаарна уу.
10. Таны **гадаад паспорт бол визийн мэдүүлгийн салшгүй нэг хэсэг.** Визийн мэдүүлгийг боловсруулах дотоод зохион байгуулалтын үүднээс шийдвэр гартал ЭСЯ-наас гадаад паспортаа буцаан авах боломжгүй. Онцгой тохиолдолд Та Элчин сайдын яамтай утсаар болон **И-Мэйлээр** холбогдоно уу.
11. **Заавал өгөх ёстой бичиг баримтууд бүрэн гүйцэд байгаа тохиолдолд л Таны визийн мэдүүлгийг хүлээн авах боломжтой гэдгийг анхаарна уу! Таны бичиг баримт дутуу хэдий ч өгөх хүсэлтэй байгаа бол хүлээн авч болох боловч дутуу бичиг баримт нь визийн мэдүүлгийг татгалзсан шийдвэрт хүргэж болно.**

ВИЗИЙН МЭДҮҮЛЭГТ ЗААВАЛ ӨГӨХ БАРИМТ БИЧИГ

ГАДААД ПАСПОРТ

- Паспорт нь сүүлийн арван жилийн дотор олгосон байна. Ямар нэгэн тамгагүй, тэмдэглэгээгүй болон наалтгүй 2 хоосон нүүртэй мөн ямар ч гэмтэл эвдрэлгүй байх ёстой.
- Паспорт нь Шенгенд байх хугацаанаас багадаа 3 сар илүү хүчинтэй.
- Паспорт нь эзэмшигчийн гарын үсэгтэй байна мөн эзэмшигчийн царайг зургаас нь хараад таних боломжтой байх ёстой.
- Эзэмшигчийн мэдээлэл бүхий нүүр болон олгосон виз (Шенген, Англи, АНУ, Өмнөд Солонгос, Япон гэх мэт), хилээр орсон, гарсан тамгатай хуудасны хуулбар авчирсан байна. (Урьд өмнө эзэмшиж байсан гадаад паспортууд мөн адил.)
- Виз мэдүүлэгч гадаадын иргэн бол:* Монгол Улсад оршин суух зөвшөөрөл болон Монгол Улс руу эргэн нэвтрэх хүчинтэй виз хамт хавсаргах.

МЭДҮҮЛГИЙН МАЯГТ

- Бүрэн гүйцэд бөглөж, гарын үсгээ зурсан Шенгений визийн VIDEX маягт.

ЦЭЭЖ ЗУРАГ (1 ЗУРАГ) WWW.BIOMETRISCHES-PASSBILD.DE

- Цээж зураг сүүлийн 6 сарын дотор авахуулсан 35x45 мм хэмжээтэй байх ёстой.
- Цээж зураг цагаан эсвэл цайвар саарал арын дэвсгэртэй байна.
- Цээж зургийг янзалж өөрчлөөгүй, биометрийн шаардлагад нийцсэн байх ёстой.

АЯЛЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ

- Шенгений нутаг дэвсгэрт хүчинтэй болон Шенгенд байх нийт хугацааг хамарсан даатгал байх бөгөөд багадаа **30.000 Евротой тэнцэх нөхөн олговортой** байна.
- Аяллын эрүүл мэндийн даатгал нь **Covid-19-р өвчилсөн тохиолдолд болон өөр ямар нэгэн эмчилгээний хязгаарлалт эсвэл хассан зүйл байх ёсгүй** бөгөөд ямар ч тохиолдолд 30.000 Евротой тэнцэх нөхөн олговортой байх ёстой.

НИСЛЭГИЙН ТИЙЗ ЗАХИАЛГА

- Таны нислэг хэзээ вэ?** Нислэгийн огноо, чиглэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл бүхий **онгоцны тийзийн ирж буцах захиалгыг** хавсаргаж өгнө.
- Та визийн мэдүүлэг өгөхдөө нислэгийн **тийзийн төлбөрийг төлсөн байх шаардлагагүй!**

ГЭР БҮЛ, ТӨРӨЛ САДАН, НАЙЗ, ТАНИЛЫНДАА ЗОЧЛОХ

Гэр бүлийн болон төрөл садны харилцааг нотлох баримт, жишээ нь: төрсний гэрчилгээ, гэрлэлтийн баталгаа гэх мэтээс гадна **урьж буй этгээдийн гадаад паспорт эсхүл иргэний үнэмлэхийн хуулбар болон тухайн оронд оршин сууж буй гадаадын иргэн бол хүчин төгөлдөр оршин суух зөвшөөрлийн хуулбарыг хавсаргана**

БАТЛАН ДААЛТТАЙ УРИЛГА

- Албан ёсны урилга (эх хувь + 1 хувь хуулбар) + урьж буй этгээдийн гадаад паспорт эсвэл иргэний үнэмлэхийн хуулбар болон оршин суух зөвшөөрлийн хуулбар + урьж буй хүнтэй садан төрлийн холбоотой бол:** иргэний бүртгэл мэдээллийн лавлагааны хуулбар **герман/англи хэл дээрх орчуулгын хамт эсвэл төрсний гэрчилгээ, гэрлэлтийн баталгааны хуулбар орчуулгын хамт, найз нөхдийн холбоотой бол:** хамт авахуулсан гэрэл зураг гэх мэтийг хавсаргаж болно.
 - **Герман:** Оршин суугаа хотынхоо Гадаадын Харьяат Иргэдийн газраас (Ausländerbehörde) батлан даалтын маягт (**Verpflichtungserklärung**) авна.
 - **Бельги, Люксембург, Словени, Латви** : Албан ёсны батлан даалтын маягт дээрх уригч этгээдийн гарын үсэг баталгаажсан байх ёстой бөгөөд холбогдох байгууллагын зөвшөөрсөн тамга тэмдэгтэй байна.
 - **Дани, Испани, Португал, Грек, Исланд:** Албан ёсны урилгын маягт дээрх урьж буй хүний гарын үсэг баталгаажсан байх ёстой. Энэхүү батлан даалтын маягт тухайн улсын холбогдох байгууллагын цахим хуудаснаас авч болдог. Батлан даалтын маягттай хамт уригч тал өөрийн орлогын баримтуудыг (сүүлийн 3 сарын цалингийн тодорхойлолт, дансны гүйлгээний 3 сарын хуулга болон үүнтэй адилтгах баримт) хамт илгээнэ.
 - **Мальта:** “Declaration of Proof” маягт дээрх гарын үсгийг баталгаажсан байх бөгөөд урьж буй хүний цалингийн тодорхойлолт, орлого болон үүнтэй адилтгах баримтыг хамт илгээнэ.
 - **Финланд:** Уригч этгээдийн гарын үсэгтэй бичмэл урилга(албан ёсны маягт байхгүй)
- Аль ч орноос ирсэн урилга нь **сүүлийн 6 сарын дотор** олгосон байх ёстой
- Та гэр бүл, төрөл садан , найз эсвэл танилындаа байрлах уу?** Уригч этгээдийн орон байрны түрээсийн гэрээний хуулбарыг хавсаргаж өгөөрэй.

БАТЛАН ДААЛТТАЙ УРИЛГА БАЙХГҮЙ, УРИГЧ НЬ ЗАРДЛЫГ ХАРИУЦАХГҮЙ БОЛ:

- Уригч этгээдээс ирүүлсэн албан бус урилга (formlose Einladung),** гадаад паспортын эсвэл оршин суух зөвшөөрлийн хуулбар.
- Урьж буй хүний нэр, хаяг, гарын үсэгтэй **албан бус урилга** нь виз мэдүүлэгчийн овог нэр, байрлах газар, Шенгений нутаг дэвсгэрт байх хугацааг тодорхой бичнэ. Виз мэдүүлэгчтэй ямар харилцаа хамааралтай, урьсан шалтгаан болон аяллын санхүүжилтийг хэн хариуцах талаар тодорхой бичсэн байх ёстой.

АЯЛАХ ЖУУЛЧЛАХ

АЯЛЛЫН ЗОРИЛГО ТОДОРХОЙ БАЙХ

- Таны аяллын төлөвлөгөө, зорилго юу вэ?** Интернэтээс элдэв зураг, түгээмэл мэдээлэл хэвлэж өгөхийн оронд Шенгений аль орнуудаар ямар зорилгоор аялах гэж байгаагаа **дэлгэрэнгүй бичмэл тайлбар** герман эсвэл англи хэл дээрх орчуулгатай бичээрэй. Таны аяллын төлөвлөгөө, маршрут ойлгомжтой, итгэл үнэмшил төрүүлэхүйц байх хэрэгтэй.
- Та хаана байрлах вэ?** Шенгений орнуудад байх нийт хугацааг хамарсан **зочид буудлын захиалга (буудлын захиалгыг баталгаажуулсан код)** эсвэл түүнтэй адилтгах баримт хавсаргаарай.

БИЗНЕСИЙН ЗОРИЛГООР ЗОРЧИХ, МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТАД ХАМРАГДАХ

Бизнес зорилгоор виз мэдүүлэхэд дараах зүйлийг бүрдүүлэх ёстой:

- Шенгений орон дахь харилцагч байгууллагаас илгээсэн урилга. Энэхүү урилга нь байгууллагын албан бланк дээр эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамгатай байхаас гадна:
 - Уригч компанийн нэр, холбоо барих мэдээлэл
 - Виз мэдүүлэгчийн овог нэр, байгууллагын нэр, хашиж буй албан тушаал
 - Аяллын зорилго болон үргэлжлэх хугацаа
 - **Аяллын санхүүжилт.** Уригч тал нь аяллын зардлыг хариуцаж байгаа хэдий ч виз мэдүүлэгч нь аяллаа өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх чадамжтай гэдгийг батлах баримт (өөрийн дансны хуулга гэх мэт) хавсаргаж өгөх хэрэгтэй гэдгийг анхаарна уу!

ҮЗЭСГЭЛЭН ЯАРМАГТ ОРОЛЦОХ

- Үзэсгэлэн яармаг үзэх: Үзэсгэлэн яармаг зохион байгуулагчаас ирүүлсэн виз мэдүүлэгчийн нэр, ажил олгогчийн нэр бүхий урилга болон үзэсгэлэн яармаг руу нэвтрэн орох тасалбар.
- Үзэсгэлэн яармагт оролцож буй тохиолдолд: Оролцогчийн үнэмлэх, талбай түрээслэх захиалгын баримт болон түрээсийн төлбөр хийсэн баримт.

ДАДЛАГАЖИГЧ (PRAKTIKANTEN) / HOSPITANTEN

- Дадлага хийх гэрээ/урилгын агуулгад
 - Цалингийн хэмжээ
 - Ажил олгогчийн нэр, холбоо барих мэдээлэл
 - Дадлага / Ажлын төрөл
 - Дадлага / Ажил эхлэх болон дуусах огноо
 - Байрлах газрын баримт: Байрны түрээсийн гэрээ эсвэл ажил олгогч орон байраар хангах тухай тодорхойлолт.
- Дадлагаар ажиллахад шаардагдах боловсрол, мэдлэг, үр чадвартайг батлах баримтыг герман эсвэл англи хэл дээрх орчуулгын хамт өгнө.

ЭРДЭМТЭД / СУДЛААЧИД

- Уригч байгууллагатай хийсэн хөдөлмөрийн гэрээ эсвэл тэтгэлэгт хамрагдах болсон тухай баримт
- Эрхлэх ажлын төрөл, цалингийн хэмжээ, үргэлжлэх хугацааны талаарх мэдээлэл
- Аяллын зардал болон байрлах зардлыг хэн хариуцаж байгаа тухай мэдээлэл.
- Виз мэдүүлэгч өөрөө хариуцаж байгаа бол **сүүлийн 6 сарын дансны дэлгэрэнгүй хуулга QR код эсвэл банкны тамгатай**

САНХҮҮГИЙН ЧАДАМЖ, ТОГТВОРТОЙ ОРЛОГЫН БАРИМТ

Виз мэдүүлэгч нь Шенгений нутаг дэвсгэрт байх нийт хугацаа болон эх орон/ирсэн улс руугаа буцах хангалттай санхүүгийн чадамжтай бөгөөд өөрийн байнгын оршин суугаа газарт тогтмол мөнгөн орлоготой, санхүүгийн холбоо, хамааралтай гэдгээ баримтаар батлах ёстой.

Банкны дансанд богино хугацаанд их хэмжээний мөнгө байршуулах нь тогтвортой орлого, санхүүгийн чадамжтай гэдгийг хангалттай нотолж чадахгүй болохыг анхаарна уу!

ВИЗ МЭДҮҮЛЭГЧ ТӨРИЙН АЛБАН ХААГЧ, АЖ АХУЙН НЭГЖИЙН АЖИЛТАН БОЛ:

- Ажил олгогч байгууллагын албан бланк** дээр виз мэдүүлэгчийн албан тушаал, ажил эрхэлсэн хугацаа, цалингийн хэмжээ, аяллын хугацаанд амралт, чөлөө авсан тухай тодорхойлолтыг герман эсвэл англи хэл дээрх орчуулгын хамт

- сүүлийн 3 сарын цалингийн орлого орсон дансны мэдээлэл (хувийн дансны сүүлийн 3 сарын дэлгэрэнгүй хуулга QR код эсвэл банкны тамгатай)
- ТҮЦ машин / E-Mongolia -аас хэвлэн гаргасан сүүлийн 1 жилийн нийгмийн даатгалын лавлагаа (орчуулах шаардлагагүй)

ВИЗ МЭДҮҮЛЭГЧ ХУВИАРАА АЖИЛ ЭРХЛЭГЧ БОЛ:

- Өөрийн нэр дээрх ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, татварын газрын тодорхойлолт
- Компанийн** сүүлийн 6 сарын банкны дэлгэрэнгүй хуулга нь QR код эсвэл банкны тамгатай
- Виз мэдүүлэгчийн сүүлийн 6 сарын банкны дэлгэрэнгүй хуулга нь QR код эсвэл банкны тамгатай
- Нийгмийн даатгал** төлдөг бол ТҮЦ машин / E-Mongolia -аас хэвлэн гаргасан **англи хэл дээрх сүүлийн 1 жилийн лавлагаа**

ВИЗ МЭДҮҮЛЭГЧ ТЭТГЭВЭРТ ГАРСАН БОЛ:

- E-Mongolia-с хэвлэн гаргасан **Өндөр настны тэтгэвэр тогтоолгосон хуудас** (англи хэл дээр гаргах боломжтой)
- Виз мэдүүлэгчийн сүүлийн 6 сарын банкны дэлгэрэнгүй хуулга нь QR код эсвэл банкны тамгатай
- Байгаа бол:** Өөрийн нэр дээрх эд хөрөнгө, санхүүгийн чадамжийг нотлох бичиг баримт (орон сууц, газар өмчлөх эрхийн гэрчилгээ, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, мал, аж ахуй, газар тариалан эрхэлж буй баримт гэх мэт) хуулбар, герман/англи хэл дээрх орчуулгын хамт өгч болно.

ВИЗ МЭДҮҮЛЭГЧ ОЮУТАН ЭСВЭЛ ЕБС-ИЙН СУРАГЧ БОЛ:

- Хэддүгээр семестр/ангид, ямар мэргэжлээр сурч буй талаар дэлгэрэнгүй бичсэн бөгөөд виз мэдүүлэх хугацаанд амралттай, чөлөө авсан тухай **сургуулийн тодорхойлолтыг** эх хувиар, герман/англи хэл дээрх орчуулгын хамт өгнө
- Төрсний гэрчилгээ** (Эх хувь + хуулбар) герман/англи хэл дээрх орчуулгын хамт
- Аяллын зардлыг хэрхэн санхүүжүүлэх тухай тайлбар**
- Насанд хүрээгүй** виз мэдүүлэгч бол: виз мэдүүлэхэд **эцэг эх хоёул биечлэн ирж маягт дээр гарын үсэг зурна.**

Эцэг эхийн аль нэг нь ганцаар асран хамгаалах эрхтэй бол холбогдох шүүхийн шийдвэр эсвэл нас барсны гэрчилгээг хуулбар орчуулгын хамт өгнө.

ВИЗИЙН МЭДҮҮЛГИЙН ХУРААМЖ

Визийн мэдүүлгийн хураамж 90,00 евро ба үүнтэй тэнцэх Монгол төгрөгөөр төлнө.

- 6 нас хүрээгүй хүүхэд, Европын Холбооны иргэдийн эхнэр/нөхөр, тэдгээрийн насанд хүрээгүй хүүхдүүд визийн хураамжаас чөлөөлөгдөнө.
- 6-12 насны хүүхдүүд 45,00 еврогийн визийн хураамжийг төлнө.

Визтэй холбоотой мэдээллийг та манай цахим хуудаснаас авах боломжтой: www.ulan-bator.diplo.de

Танд нэмж тодруулах зүйл байгаа бол та [холбоо тогтоох маягт](#) ашиглан асуугаарай.

Буруу мэдээллээс болж мөнгө болон цагаа бүү алдаарай!

Гуравдагч этгээд, зуучлагч агентлаг, аяллын компани болон тэдний цахим ертөнцөд түгээж буй мэдээлэл бүрэн бус, буруу зөрүү, хуучирсан байх нь түгээмэл. Үүнээс үүдэж таны визийн мэдүүлгийг шийдвэрлэх хугацаа удаашрах, цаашлаад танд санхүүгийн хохирол учирч болзошгүй. Визийн мэдүүлгийн талаар Танд төлбөртэй үйлчилгээ санал болгож буй хувь хүн, албан байгууллагатай хянуур, сонор сэрэмжтэй харилцах хэрэгтэй.

Германы элчин сайдын яамны бүх мэдээлэл, маягт болон заавар үнэ төлбөргүй байдаг.

ДАРААХ ЗАРЧМУУДЫГ БИ УНШИЖ ОЙЛГОСОН

- Хуурамч бичиг баримт эсвэл худал мэдээлэл өгөх нь визийн мэдүүлгийг татгалзах маргаангүй шалтгаан мөн бөгөөд Герман улс руу цаашлаад Шенгений бусад улс руу нэвтрэхийг хориглох шийдвэр гаргахад хүрч болно.
- Дутуу бичиг баримт өгөх нь визийн мэдүүлгийг татгалзах шалтгаан болох боломжтой.
- Явахаар төлөвлөж буй өдрөөс багадаа 2 долоо хоногийн өмнө визийн мэдүүлгээ өгөх ёстой гэдгийг миний бие мэдэж байгаа болно. Дээрх хугацаанаас хоцорч өгсөн визийн мэдүүлгийг аялахаар төлөвлөж буй өдрөөс өмнө шийдвэрлэх баталгааг Элчин сайдын яам өгөх боломжгүй гэдгийг би ойлгож байна.
- Олон удаа нэвтрэн орох виз мэдүүлсэн тохиолдолд эхний болон дараа дараагийн бүх аяллын нийт хугацааг хамарсан эрүүл мэндийн даатгалтай байх ёстой гэдгийг би мэдэж байгаа.
- Гарын үсэг зурснаар би дээрх бүх мэдээлэл, зарчмуудыг уншиж танилцсан бөгөөд утга агуулгыг ойлгосон гэдгийг баталж байна.
- Гарын үсэг зурснаар Элчин сайдын яамнаас над руу цахим шуудан эсвэл утсаар (маягтад бичигдсэн мэдээллийн дагуу) холбоо тогтоож болно гэдгийг зөвшөөрч байна.

И-МЭЙЛ: _____

(дармал үсгээр гаргацтай бичнэ үү)

Виз мэдүүлэгчийн гарын үсэг